баруун өмнөд хэсэгт оршин Сантус усан боомтыг, Өмнөд Америкийн зүүн эрэгт байрлах Ило боомттой холбосон төмөр

сайжруулахын тулд юуны түрүүн дэд бүтцээ хөгжүүлэх ёстой хэмээн мэргэжилтнүүд үзэж байгаа. Тиймээс ч

засгийг сэргээх хамгийн том найдвар юм. Энэ төмөр зам нь стратегийн хувьд маш чухалд тооцогдох нь гарцаагүй.

зам барьсан түүхтэй.

**Ю.ДЭЛГЭРМА**

---

**АРД ДААТГАЛ КОМПАНИ**

Эрхэм зорилго
**Даатгуулагчийн хэрэгцээнд тохируулсан, ёс зүйг баримтласан, даатгалын шилдэг үйлчилгээг бид үзүүлнэ.**





**BDO**

Tel: +976 77404041
Fax: +976 77451150
www.bdo.mn

Level 10, AB Center Building, University Street, 11 th Khoroolol, khoroo-6, Sukhbaatar District-14193, Ulaanbaatar, Mongolia

Утас: +976 77404041
Факс: +976 77451150
www.bdo.mn

АБ Цэнтр, 10 давхар
СБД-6, 11-р хороолол
Улаанбаатар Монгол улс
14193


## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**"АРД ДААТГАЛ"ХХК-ийн**
**Хувь нийлүүлэгчдэд**

Бид "Ард Даатгал" ХХК-ийн (цаашид "Компани" гэх) 7-40 дугаар хуудсанд тусгагдсан 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Орлого үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

**Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага**

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол Улсын хууль болон даатгалын багц дүрмийн дагуу бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй. Үүнд санхүүгийн тайлангуудыг алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг зохион, ажиллуулан, хэвийн түвшинд сахих; тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх; нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

**Аудиторын үүрэг хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын үл үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

**Аудиторын дүгнэлт**

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх "Ард Даатгал" ХХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн тухай Монгол Улсын хууль, даатгалын багц дүрмийн дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Ард Даатгал" ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

БДО АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо:
Тусгай зөвшөөрөл: 009-1997

## АРД ДААТГАЛ
## Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
## 2014 оны 12 сарын 31-ний өдрөөрх
## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| | 2014 оны 12 сарын 31 мян.төг | 2013 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| Өмч, барилга, тоног төхөөрөмж | 256,902 | 287,66 |
| Бондоорх хөрөнгө оруулалт | - | 300,00 |
| Урьдчилж төлсөн зардал | 546,614 | 538,39 |
| Бараа материал | 33,865 | 30,21 |
| Худалдааны ба бусад авлага | 2,890,534 | 1,219,92 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс | 4,961,545 | 4,794,59 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | 8,689,460 | 7,170,79 |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ** | | |
| Өр төлбөр | | |
| Нөөцийн сан | 4,163,414 | 3,239,5 |
| Худалдааны ба бусад өглөг | 4,135 | 5,4 |
| Орлогын татварын өглөг | 14,996 | |
| Бусад татвар шимтгэлийн өр | 42,570 | 2 |
| Өр төлбөрийн дүн | 4,225,133 | 3,245,2 |
| Эзэмшигчдийн өмч | | |
| Дүрмийн сан | 3,500,000 | 2,750,( |
| Хуримтлагдсан ашиг | 964,327 | 1,175,: |
| Эзний өмчийн дүн | 4,464,327 | 3,925,5 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ** | 8,689,460 | 7,170,7 |